



**ХЭНТИЙ АЙМАГ
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 05 сарын 07 өдөр

Дугаар A/09

Бор-Өндөр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.15, 16.5.5 дахь заалт, Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоол "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын 3.6.1 дэх хэсэг, Аймгийн Засаг дарга, сумын Засаг даргатай байгуулах "Төрийн чиг үүргийг төлөөлөн гүйцэтгэх" гэрээний 3.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд "Бүх нийтээр мод тарих" хөдөлгөөнийг сумын хэмжээнд зохион байгуулах ажлын хүрээнд модны суулгац худалдаж авах 5.000.000 (таван сая) төгрөгийг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаас зарцуулсугай.

2. Модны суулгац худалдаж авах 5.000.000 (таван сая) төгрөгийг Засаг даргын Тамгын газрын байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (О.Мөнхцэцэг)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

3.УУГАНЖАРГАЛ

